

СЭТГҮҮЛ ЗҮЙН ЁС ЗҮЙН “ХОР УРШГИЙГ БУУРУУЛНА” ЗАРЧМЫГ ТАЙЛБАРЛАХ НЬ

Д.Идэржаргал*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)

Түлхүүр үгс: ёс зүй, хор уршиг, хор хохирол, үнэнийг мэдээлэх, үүргийн тэнцвэр, ёс зүйн шийдвэр.

Олон улсад сэтгүүл зүйн ёс зүйн төлөө ажилладаг мэргэжлийн холбоод сэтгүүл зүйн ёс зүйн зарчмын агуулгыг салбарын өөрчлөлт, хөгжилд нийцүүлэн нэмж баяжуулж байдаг. Тэдгээр олон кодоод (accountablejournalism.org, 2020) үргэлж давхцаж байдаг сэтгүүлчийн ёс зүйн үндсэн зургаан зарчим бий. Эдгээр нь (www.spj.org, 2020):

1. Үнэнийг эрэлхийлж, үнэнийг мэдээлнэ
2. Хор уршгийг бууруулна
3. Заль мэх, төөрөгдүүлэлт, худал ташаа арга ашиглахгүй
4. Ашиг сонирхлын зөрчилгүй ажиллана
5. Хувийн амьдралыг хүндэтгэнэ
6. Ялгаат байдлыг хүлээн зөвшөөрнө (сүүлд нэмэгдсэн) болно.

Энэ удаад хор уршгийг бууруулна зарчмыг тайлбарлаж, түүнд хамааралтай олон улсын болон Монголын зарим кэйсэд дүн шинжилгээ хийлээ.

Ёс зүйн олон шийдвэр үүргээ биелүүлэх, үйлдлийнхээ үр нөлөөнд хариуцлага хүлээх хоёрын дунд

тэмцэлдэж байдаг. Тиймээс ёс зүйн шийдвэр гаргахдаа өөртэйгөө болон ажлынхантайгаа мэтгэлцээн өрнүүлж, зөв асуултуудыг асуух ёстой. Хор уршгийг бууруулах зарчмын хувьд эдгээр асуултууд нь “Хэрвээ бид энэ түүхийг нийтэлбэл хэнд хор уршиг учруулах вэ?”, “Олон нийт үнэнийг мэдэхийн ач тус нь тэр хүнд учруулах хор хохирлоос илүү жин татаж байна уу?” юм.

Үйлдлийнхээ үр дагаврыг авч хэлэлцэх нь жижиг боловч чухал алхам. Өөрөөр хэлбэл, хор уршгийг бууруулахын тулд сэтгүүлч өөрийнхөө бүтээлийн үр дагаварт мэдрэмжтэй байхыг шаарддаг.

Ёс зүйн кодуудад “Мэдээлэл цуглуулж, сурвалжилснаас үүдэн гарч болох хор уршиг, бэрхшээлийг таньж мэд” хэмээн заасан байдаг нь мэдээлэл түгээх эрх нь эрдүү байхын лиценз биш гэдгийг сануулж буй хэрэг.

Хор уршгийг бууруул гэдэг нь асуудалд хүнлэг байдлаар ханд гэсэн үг. Таны бичиж буй зүйлд өртөж буй хүнд бага ч болов хүндэтгэл үзүүл. Маш олон хүний хувьд сэтгүүлчийн бүтээлийн нэг хэсэг болох нь ховор, бүр амьдралд ганц тохиох явдал ч байж болно. Сэтгүүлч олон жилийн өмнө

бичсэн түүхээ мартаж, өөр асуудлыг бичиж байхад түүний бүтээлийн баатар нийтлэлийн үр нөлөөн дор урт хугацаанд ч амьдарч болохыг мартаж болохгүй.

Ёс зүйтэй сэтгүүлчид эх сурвалж, субъект, хамтран зүтгэгчдэдээ хүндэтгэлтэй ханддаг. Хүндэтгэлтэй хандана гэдгийг тодруулж задалбал:

- Сэтгүүлчийн бүтээлийн үр дүнд өртөж болох хүнд энэрэнгүй хандах;
- Хүүхэд, мэдээлэл өгч байсан туршлагагүй эх сурвалжтай уулзахдаа мэдрэмжтэй хандах;
- Гай зовлон, уй гашууд өртөгсдөөс ярилцлага авах, тэдний зургийг нийтлэхдээ болгоомжтой хандах;
- Мэдээлэл цуглуулж, сурвалжилснаас үүдэн гарч болох хор уршиг, бэрхшээлийг таньж мэдэх;
- Сенсацлах явдлыг өөгшүүлэхээс болгоомжлох;
- Насанд хүрээгүй сэжигтэн, гэмт хэргийн хохирогчдыг таниулахаас болгоомжлох;
- Шүүхийн шийдвэрээр нотлогдоогүй тохиолдолд гэмт хэргийн сэжигтний нэр усыг зарлахдаа бодлоготой хандах;
- Гэмт хэргийн сэжигтний шүүгдэх эрхийг олон нийтийн мэдэх эрхтэй тэнцвэржүүлэх зэрэг болно.

Кэйс 1: Засгийн газартай хамтарсан нь (<https://www.spj.org/ecs1.asp>). Хэдэн жилийн өмнө АНУ-ын түүхэн дэх шоронгийн хамгийн том бослого гарав. 2005 оны нэгдүгээр сарын 18-нд Аризонагийн шоронгийн цогцолборт хоёр хоригдол гараар хийсэн зэвсгээр зэвсэглэж, шоронгийн хамгаалалтын цамхгийг хяналтдаа авчжээ. Тэд засан хүмүүжүүлэх хоёр офицерыг барьцаалснаас эрэгтэйг нь суллаж, эмэгтэйг нь бууж өгөхийнхөө өмнө буюу хоёр

долоо хоногийн дараа (хоёрдугаар сарын нэгэнд) суллажээ. Гэвч олон нийт хэрэг явдлыг дуусах хүртэл юу ч мэдээгүй. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл (ХМХ)-үүдийг шоронд 500 метрээс дотогшоо ойртохыг хориглосон бөгөөд нисдэг тэрэг нисэхийг ч хязгаарлажээ. Эрх барих байгууллагын төлөөлөл энэ явдлыг тайлбарлахдаа шоронгийн хоёр хамгаалагчийн аюулгүй байдлыг харгалзан үзсэн бөгөөд муж улсын бүхий л ХМХ-ийн эрхлэгчидтэй холбогдож тодорхой үндсэн мэдээллийг цацахгүй байхыг ятгасан байна. Бослого үргэлжлэх үеэр ХМХ-ийн мэдээлэл хоригдлуудад хүрч тэдэнтэй хийх тохироог нурааж магадгүй гэж үзжээ. Иймд төрийн албаныхан хэрэгт холбогдсон хүмүүсийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх болон бослого хэрхэн эхэлсэн, бослогын улмаас ямар хор хохирол учирсныг мэдээлэхээс татгалзсан байна.

Харин Аризонагийн ХМХ-үүд засгийн газрын саналыг хүлээж авчээ. Гэхдээ энэ нь барьцаалагчидтай хийх тохироог нурааж магадгүй гэсэн болгоомжлолоос бус гэм буруугүй хэн нэгэнд хор хохирол учруулах зайлшгүй магадлалаас үүдсэн байна. Хэвлэлүүд төрийн албаныхнаас өөр эх сурвалжаас хангалттай мэдээлэл авчихсан байж. Тэд бүр барьцаалагчид гэж сэжиглэж байсан хоригдлуудын ар гэрийнхэнтэй хүртэл уулзаж ярилцлага авсан байлаа. Гэхдээ бослого дуусах хүртэл хүлээн авагчдаа барьцаалагдсан хүмүүсийн нэрийг огт задлаагүй бөгөөд барьцаалагчдын гэмт хэргийн түүх, мэдээллийг ч мөн нууцлахаар хатуу шийджээ. Хоригдлууд хүн зодсон, барьцаалсан, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн зэрэг хэргээр ял эдэлж байсан гэдгээс бослогын үеэр юу болсон байх магадлалтайг, яагаад

эмэгтэй хамгаалагчийг сүүлд сулласныг таамаглаж болно. Энэ бол хөдөлмөр зарцуулж, олон хүн сонирхож болох мэдээллийг олж авсан ч гэлээ гэм буруугүй хэн нэгний амьдралд насан туршид нь арилшгүй хор хохирол учруулахгүй гэсэн ёс зүйн шийдвэр байв.

Кэйс 2: Бэлгийн гэмт хэргийн хохирогчдыг нэрлэсэн нь. 2002 оны зургаадугаар сарын тавны өдөр 14 настай Элизабет Сمارт Юта мужийн Солт Лэйк дэх гэрийнхээ унтлагын өрөөнөөс хулгайлагджээ. Элизабетийн эцэг эх хэргийг илрүүлэхийн тулд, хүүхэд хулгайлж буйг олон нийтэд сэрэмжлүүлэхийн тулд орон нутгийн болон үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллажээ. Хэрэг гарснаас хойш 9 сарын дараа эгчийгээ хулгайлагдсаныг гэрчилсэн дүү нь түүнийг авч явсан хүний дуу хоолой хэрэг болохоос хэдэн сарын өмнө тэднийд ажиллаж байсан хүнийхтэй адилхан болохыг санажээ. Энэ явдал мөрдөн байцаалтад асар их дэм болж Элизабетийг аварч чадсан нь үндэсний хэмжээнд дуулиант мэдээлэл болов.

Охиныг хулгайлсан хүүхэн, залуу хоёр өмнө нь бэлгийн хүчирхийллийг оролцуулаад олон гэмт хэрэг үйлдсэн гэж бүртгэгдсэн байжээ. Тэднийг шүүх хурал хэрэг хүлээх чадваргүй гэж

хойшлогдсоор 2009 оны 11 дүгээр сард эмэгтэйд 15 жилийн ял оноож, эрэгтэйг шүүх хурлыг дахин товлосон байна (ялын тухай мэдээлэл олдсонгүй).

Элизабетийг гэртээ ирсний дараа түүний эцэг эх Эд болон Лоис Сمارт нар гэр бүлийнхээ зовлон зүдгүүрийн талаар ном бичжээ. Тэд охиныхоо хамт олон удаа ярилцлага өгсөн байна. Зарим сэтгүүлчид Элизабеттай зовлонт сэдвээр ярилцахдаа мэдрэмжтэй хандсан бол зарим нь түүнийг сэтгэл санаагаар унагаах хэмжээнд шалж байв.

Шаргал үст охины хэргээс сэтгүүлчид дараах ёс зүйн асуултуудыг өөрсдөдөө тавьж болно. Бэлгийн хүчирхийллийн хохирогч гэж сэжиглэгдэж буй хүүхдийн нэрийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах нь зүйтэй юу? Хэрвээ барьцаалагдсан, хулгайлагдсан хүмүүсийн нэр усыг зарласны дараа тэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн нь тодорхой болбол яах вэ? Тэдний нэрийг тухайн мөчөөс бичихээ болих уу?

Ийм асуултууд тулгарсан тохиолдолд шийдвэр гаргагчид нь сэтгүүлчид, редакторууд бөгөөд аль хэдийн хохирсон хүмүүст дахин аюул учрахад “хувь нэмрээ” оруулсан шалтгаан нь болсон үйл явдлыг цогцоор өгүүлэх, рейтинг, борлуулалтын тоо хэмжээгээ өсгөх болон бусад ХМХ-үүдээс давуу байх гэх мэт олон хүчин зүйлээс

«

Сэтгүүлчийн баримтлах ёстой эхний зарчим үнэнийг өгүүлэх, хоёр дахь нь хор уршгийг бууруулах. Хэрвээ үнэн нь олон нийтийн эрх ашигт амин чухал биш бөгөөд гэм зэмгүй хэн нэгэнд хор уршиг учруулахаар байвал түүнийг өгүүлэхээс татгалзах шаардлагатай. Эсвэл нарийн тодорхой өгүүлэхгүй байх ёстой. Хор уршгийг бууруулах гэдэг ойлголт “сенсацыг өөгшүүлэхээс татгалзах”, “гэмт хэргийн насанд хүрээгүй сэжигтэн, бэлгийн гэмт хэргийн хохирогчийн нэр усыг зарлахдаа хаширлах” зэрэг ч багтана

»

Ийм асуултууд тулгарсан тохиолдолд шийдвэр гаргагчид нь сэтгүүлчид, редакторууд бөгөөд аль хэдийн хохирсон хүмүүст дахин аюул учрахад “хувь нэмрээ” оруулсан шалтгаан нь болсон үйл явдлыг цогцоор өгүүлэх, рейтинг, борлуулалтын тоо хэмжээгээ өсгөх болон бусад ХМХ-үүдээс давуу байх гэх мэт олон хүчин зүйлээс

шалтгаалсан байдаг. Ийм тохиолдолд хэлэлцэх ёстой ёс зүйн асуудал бол сэтгүүлчийн үйл явдлыг дамжуулах үүрэг, хүчирхийлэгдсэн хүүхдэд учрах хор уршгийг багасгах үүрэг хоёрын аль нь илүү чухал вэ тухай юм.

Сэтгүүлчийн баримтлах ёстой эхний зарчим үнэнийг өгүүлэх, хоёр дахь нь хор уршгийг бууруулах. Хэрвээ үнэн нь олон нийтийн эрх ашигт амин чухал биш бөгөөд гэм зэмгүй хэн нэгэнд хор уршиг учруулахаар байвал түүнийг өгүүлэхээс татгалзах шаардлагатай. Эсвэл нарийн тодорхой өгүүлэхгүй байх ёстойг анхаарна уу. Хор уршгийг бууруулах гэдэг ойлголтод “сенсацыг өөгшүүлэхээс татгалзах”, “гэмт хэргийн насанд хүрээгүй сэжигтэн, бэлгийн гэмт хэргийн хохирогчийн нэр усыг зарлахдаа хаширлах” зэрэг ч багтана. Эрэлхийл, бууруул, татгалз, хаширла зэрэг үгс байсаар байгаа ч үргэлж тайлбар хийх зай байдаг. Нэгэн сэтгүүлч хаширлаж үзсэн боловч нэрийг нь зарлахыг зөв хэмээн итгэж, итгэл үнэмшлийнхээ дагуу биелүүлжээ. Тэр ёс зүйн зодоо зөрчөөгүй, учир нь хаширлаж, тунгааж үзсэн. Энд дахиад л нөгөө асуулт урган гарна. Сэтгүүлчийн үйл явдлыг дамжуулах үүрэг, хүчирхийлэгдсэн хүүхдэд учрах хор уршгийг багасгах үүрэг хоёрын аль нь илүү чухал вэ?

Кэйс 3. Төрийн байгууллага сэрэмжлүүлгээрээ дахин “ялласан” нь. Монголд төрийн байгууллагын олон нийттэй харилцах алба нийгмийн сүлжээнд мэдээлэл түгээхдээ хор уршгийг бууруулаагүйгээс нэгэн гэр бүл “хүнд ноцтойгоор” хохирсон жишээ 2020 оны хоёрдугаар сард болсон юм. ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газар фейсбүүк хуудастаа донтогч залуу ээжийгээ зодож буй бичлэгийг хар тамхины хор уршгийг сэрэмжлүүлэх

зорилгоор нийтэлжээ. Бүрсгэр бичлэг дээрх нэрийг нь нууцалсан “донтогч” нь олны танил жүжигчин Т.Б болохыг нэгэн хэрэглэгч таньснаар нийгмийн сүлжээ болон ОНМХ-үүдээр энэ мэдээлэл асар хурдан тархав. Иргэнийхээ эрхийг хамгаалах ёстой байгууллага нь иргэдээ хохироож, хүний эрхийг зөрчсөн сэрэмжлүүлэг нийтэлж, түүнийг нь олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд ямар ч цензургүйгээр “уухайлан” түгээсэн нь тун харамсалтай. Энэхүү үйл явдлыг улс даяараа хэлэлцэн шүүмжилсний үр дүнд гэмт хэрэгтэн болон түүний гэр бүл хүний нүүр харж чадахгүй болтлоо нэмж хохирсон юм. Хүүдээ зодуулсан эх олон нийтийн өрөвдлөөр дахин “зодуулж”, шоронд шийтгүүлсэн донтогч сошиалд дахин “шийтгүүлэв”. Харамсалтай нь ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газар бичлэгээ устгаж хариуцлагаас мултарсан бөгөөд нэгэн гэр бүлийг хохироосон энэ гэмт хэргийнхээ төлөө олон нийтээс уучлал хүсэх ёс суртахуун дутагч. Эсрэгээрээ ёс зүйгүй зарим хэвлэлүүд өдгөө ч тухайн мэдээллийг устгаагүй, ижил нь мөн л мэргэжлийн ёс зүйгээ ухамсарлаж уучлал хүссэн нь үгүй.

Сэтгүүлч мэргэжлийн ёс зүйд үнэнийг өгүүлэх ёстой гэдэг ч гэм хоргүй хэн нэгний амьдралд насан туршийн хор уршиг учруулах тохиолдолд үнэнийг өгүүлэхээс татгалзаж болно. Дээрх кэйсүүдээс сэтгүүлчийн ёс зүйн зарчмууд бие биетэйгээ нягт харилцан хамааралтайг мөн харж болно. Тиймээс сэтгүүлчид ёс зүйтэй мэдээлэл түгээж буй эсэхээ нягтлахдаа хяналтын асуултуудыг асууж, шалгаж дадах нь чухал юм. Залуу сэтгүүлчид энэ аргыг зуршил болгон хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Хор уршгийг бууруулах хяналтын асуултууд:

- Ач холбогдлыг нэмэгдүүлж эсвэл буруулснаар утга, агуулга гажуудсан уу?
- Хам сэдэв дэх баримт, эшлэлүүд өөрсдийн өнгө аясаараа байна уу?
- Та бүтээл дэх өөр өөр байр суурийг сурвалжлахын тулд чадах бүхнээ хийсэн үү? Зөвхөн нэг талын байр суурь биш, хоёр талынх ч биш оролцогч бүх талын байр суурь.
- Та сурвалжлахдаа энэрэнгүй хандсан уу?
- Таны бүтээлд холбогдох бүх хүмүүстэй, ялангуяа мэдээ, сурвалжилгын улмаас хор уршигт өртөж болох хүмүүст хариулт хэлэх боломж олгосон уу?
- Хэрвээ тэдэнтэй холбогдож чадаагүй эсвэл тэд хариу өгөөгүй тохиолдолд та бүтээлдээ яагаад гэдгийг нь тайлбарласан уу?
- Хэрвээ эх сурвалжуудыг бүрэн дүүрэн тодорхойлоогүй бол таны бүтээлийг зөвтгөх шалтгаан байна уу?
- Таны нэвтрүүлэг эсвэл бичвэрт ноцтой алдаа эсвэл гажуудуулсан байдал гарсан бол та сайн дураараа буруугаа хүлээн зөвшөөрч, аль болох богино хугацаанд цогцоор залруулахыг оролдох уу?

Харин одоо олон улсын нэр хүндтэй хэвлэлүүдийн ёс зүйн кодуудад хор уршигийг бууруулах талаар хэрхэн тусгасныг түүвэрлэн хүргэе.

The Virginian-Pilot (Norfolk, Virginia): Шударга тоглох амлалтаа шударгаар биелүүлнэ. Бид:

- Бид найз ч бай, дайсан ч бай бүх эх сурвалжид тэгш хандана. Бид эх сурвалжуудыг тэдний өгч буй мэдээллийн үнэ цэнд үндэслэн үнэлнэ.
- Нийтлэлд хамаарах бүх талын байр суурийг тусгана. Бид нийтлэлийн гол

баримтуудтай зөрчилдөж буй нотолгоонуудын талаар юу мэдэхгүй байгаагаа уншигчдадаа илэн далангүй хуваалцана.

- Буруутгагдаж буй хүмүүст үйл явдалд хариулт өгөх боломж олгоно.
- Эх сурвалждаа хэзээ, хаана түүх, зургийг нь нийтлэх тухай амлалт бүү өг.

American Society of News Editors: Шударга тогло. Сэтгүүлчид мэдээ, нийтлэлд холбогдсон хүмүүсийн эрхийг хүндэлж, түүхийг олон нийтэд мэдээлэх нь шударга, үнэн зөв эсэхэд нягт нямбай хандана. Олон нийтэд буруутгагдсан хүнд хариулт өгөх боломжийн хамгийн түрүүнд олгоно.

National Public Radio: NPR-ийн сэтгүүлчид хүмүүсийн тухай мэдээлэхдээ шударга, хүндэтгэлтэй хандана. Тэд мэдээлэл цуглуулж, дамжуулах үед хүнийг эвгүй байдалд оруулах, хор уршиг учруулах эрсдэл гарвал нийтлэлийн ач холбогдолтой харьцуулан авч үзэж шийдвэрлэнэ. Зовлон зүдгүүр, уй гашууд өртсөн эх сурвалжтай харилцахдаа мэдрэмжтэй хандана. Хүүхэд, тухайн хэлээр сайн ярьдаггүй болон туршлагагүй эх сурвалжуудтай харилцахдаа өндөр сэрэмжтэй хандана.

The Denver Post: Шударга байдал. Товлосон хугацаа тулсан ч гэлээ мэдээний субъектүүдэд тэдэнтэй холбоотой асуудал, үйл явдал, хамгийн чухал нь буруутгалд хариулах цаг хугацаа өгөхийг эрмэлзэнэ. Бид тэдэнтэй холбогдох боломжийг бүрэн ашиглахыг оролдоно. Субъектүүдийн хариултаудыг болон хариулахгүй байгаа шалтгааныг тодорхойлохыг хичээнэ. Хариулаагүй тохиолдлыг хариулахаас татгалзсан гэж үзэж болно. Гэхдээ энэ нь хугацаа, боломж өгөөд байхад

мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй төрийн албан хаагч нарт илүү хамааралтай. Бид уншигчдадаа мэдээний субъекттэй яаж, хэрхэн холбогдох гэж хичээснээ тодорхой мэдээлэх ёстой. Мэдээ, сурвалжилга бэлдэхдээ туршлагагүй эх сурвалжтай харилцахад сорилт болдог. Бид туршлагагүй эх сурвалжид өөрсдийгөө бүрэн тодорхой танилцуулж, мэдээлэл авч буй зорилго болон хам сэдвийг тайлбарлаж өгнө. Ялангуяа гэмт хэргийн хохирогч, хүүхдүүдтэй харилцахдаа анхаарал сэрэмжтэй байна.

San Jose Mercury News: Шударга байдал. Манай редакц шударга, нягт нямбай, хараат бус ажиллана. Хуулиар ингэхийг шаарддаггүй ч Mercury News сөрөг байр сууриудад хамаарч буй эх сурвалжуудтай холбоо тогтоож, хариулт авахыг үргэлж эрмэлзэнэ.

Detroit Free Press: Шударгаар тоглоно.

- Бид хүмүүст хүн ёсоор хандаж хүндэтгэнэ.
- Бид алдаа гаргавал цаг алдахгүй залруулна.
- Бид асуудалд хамааралтай бүх талын байр суурийг тусгахыг эрмэлзэнэ.
- Бид уншигчдадаа сэтгүүл зүйн процессоо тайлбарлана.
- Бид хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл өгч байсан туршлагагүй эх сурвалжтай сэрэмжтэй харилцана.
- Бид олон нийтийн мэдэх эрхийг хангахын тулд онцгой процедурын дор эх сурвалжийг нэрлэхгүй байх боломжтой.

Эшлэл

1. Aiden White. 5 core values of journalism. Ethical journalism network. <https://accountablejournalism.org/>
2. Society of professional journalists' Code of Ethics. <https://www.spj.org/>
3. Ethics case studies. Cooperating with the Government. <https://www.spj.org/ecs1.asp>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль.М, Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд: Боть-10: Сэтгүүлчийн хөдөлмөр: Ёс зүй, хариуцлага, үнэлэмж. УБ. 2017.
2. Зулькафиль.М, Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. II боть. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ. 2016.
3. Чойсамба.Ч, Сэтгүүлчийн ёс зүйн алдаа. УБ. 2014.
4. Тунгалаг.Д, Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй. УБ. 2007.
5. Чойсамба.Ч, Ёс зүйн тухай өгүүллэгүүд. УБ. 2016.
6. www.accountablejournalism.org
7. www.poynter.org
8. www.spj.org

Summary

In this article, the author explains the principle of harm reduction, which is one of the basic principles of journalistic ethics. In doing so, two cases of journalism in the United States and one case in Mongolia related to the principle of harm reduction were analyzed. Journalism has a duty to report the truth, but it can be abdicated if it harms someone's life. Also, in order to reduce the harm, it is necessary to be humane and sensitive when reporting events and communicating with sources.